

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудас</b>
<b>1.</b>	<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-5
<b>2.</b>	<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл</b>	6-18
	<b>1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	7-11
	<b>2.Монгол улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</b>	11-14
	<b>3.“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2023.01.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</b>	14-16
	<b>4.“Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээ”-ний төсөл /Засгийн газар 2023.01.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</b>	16-18

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа;  
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Бат-Эрдэнэ, Д.Ганбат, Ц.Сэргэлэн.

**Нэг.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай  
хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх  
эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорлоо, Тагнуулын ерөнхий газрын дэд дарга С.Хүдэрчулуун, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Ц.Хүрэлбаатар, мөн газрын Хэлтсийн дарга Д.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Б.Энх-Амгалан:** Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Т

Б 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ү

г Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын “дэмжсэн” санал техникийн даатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

З

с Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар югтов.

*Уг асуудлыг 09 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Энх-Амгалан:** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 01 сарын 19-ний өдрийн хуралдааны ирцийг танилцуулъя.

Энх-Амгалан гишүүн ирсэн, Амартүвшин гишүүн ирсэн, Анужин гишүүн орон нутагт томилолттой, Аюурсайхан гишүүн ирсэн, Бат-Амгалан гишүүн ирсэн, Баттөмөр гишүүн ирсэн, Баделхан гишүүн ирсэн, С.Батболд гишүүн ирээгүй байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт томилолттой, Д.Бат-Эрдэнэ гишүүн чөлөөтэй, Булгантуяа гишүүн орон нутаг томилолттой, Ганбат гишүүн ирээгүй байна. Доржханд гишүүн ирсэн, Дэлгэрсайхан гишүүн ирсэн, Наранбаатар гишүүн ирсэн, Сэргэлэн гишүүн чөлөөтэй, Цогтбаатар гишүүн дуудаарай. Нямаагийн Энхболд гишүүн ирсэн. Ингээд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул өнөөдрийн хуралдааныг эхэлснийг мэдэгдье.

Эрхэм гишүүдэд өнөөдөр ингээд намрын чуулган завсарлахтай холбогдуулаад яаралтайгаар өргөн барьсан хэд хэдэн хуулийн төсөл байж байгаа. Хэд хэдэн тогтоолын төсөл байгаа. Тийм учраас хуралдаандаа идэвхтэй оролцохыг хүсье. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх. Засгийн газар 2023 оны 01 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хуулийн төслийг нэн яаралтай хэлэлцэхээр Засгийн газраас өргөн мэдүүлсэн.

2 дахь асуудал Монгол Улс Дэлхийн Банкны олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг 2” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 01 сарын 18-ны өдрөөр энэ хуулийн төслийг нэн яаралтайгаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн. Энийг хэлэлцэнэ.

3 дахь асуудал. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалца үзүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба улс хоорондын гэрээний төсөл Засгийн газраас 2023 оны 01 сарын 04-ний өдөр мэдүүлсэн Зөвшилцөх асуудал байгаа.

4 дэх асуудал Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай Монгол Улс болон Улс болон Бүгд Найрамдах Куба хоорондын гэрээний хэлцэл, Засгийн газраас 2023 оны 01 сарын 04-ний өдөр мэдүүлсэн зөвшилцөх асуудлыг тус тус хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу. Алга байна. Ингээд хэлэлцэх суудалдаа оръё. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор ажлын хэсгийн гишүүдийг оруулъя.

**Эхний асуудлаар Улсын Их Хурлын даргын захирамж гарсан. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Энийг уншиж танилцуулъя.**

Улсын Их Хурлын даргын захирамж 2023 оны 01 сарын 18-ны өдөр. Дугаар номер 13. Хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн захирамжлах нь.

Нэг.Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 сарын 18-ны өдөр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцэх асуудлын тов, дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлсүгэй.

Хоёр.Энэ нь захирамжийн 1-д заасан хуулийн төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Энх-Амгаланд даалгасугай гэсэн ийм Их Хурлын дарга Г.Занданшатар гэсэн ийм захирамж гарсан байна. Тэгээд энэ захирамжийн дагуу асуудлыг хэлэлцүүлъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсэг танилцуулъя. Ням-Осорын Учрал Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сай, Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Ганбатын Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга, Сүрэнжавын Хүдэрчулуун Тагнуулын ерөнхий газрын дэд дарга, Цэгмэдийн Хүрэлбаатар Тагнуулын ерөнхий газрын Мэдээлэл аюулгүй байдлын газрын дарга, Даваадоржийн Ганзориг Тагнуулын ерөнхий газрын мэдээлэл аюулгүй байдлын газрын Хэлтсийн дарга эдгээр хүмүүс оролцож байна.

Ингээд хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Их хурлын гишүүн Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг өгье.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлэг буюу засаглалын бодлогын 4.1.2-т хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн технологийн аюулгүй байдалд зохистой харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 82 дугаарт Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 08 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс Олон нийтийн

сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын зүгээс боловсруулан танилцуулж байна.

Технологийн хөгжилтэй зэрэгцэн бидний өдөр тутмын амьдрал цахим орчин олон нийтийн сүлжээнд өрнөх болж, худалдаа наймаагаа хийх, мэдээлэл солилцох, үзэл бодлоо илэрхийлэх, хуваалцах зэрэг явдал нь ердийн үзэгдэл болж хэвшсэн байна. Технологийн дэвшил нь мэдээлэл бараа, үйлчилгээ солилцоонд өндөр хурд авчирч холыг ойртуулж 2-ыг уулзуулж байгаа хэдий ч үүнийг дагасан сөрөг үр дагавар, аюул эрсдэл бидний өмнө үүсэж байна.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо, хохирол асар хурдацтай өсөн нэмэгдэж байна. Цагдаагийн байгууллагын мэдээлснээр зөвхөн 2022 онд цахим орчинд үйлдэгдсэн 8563 гэмт хэрэг байна. Ганцхан жилийн дотор цахимаар залилах гэмт хэрэг 99.8 хувиар буюу 2 дахин, алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг 95.2 хувиар, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг 70.7 хувиар, хулгайлах гэмт хэрэг 37 хувиар, хүүхдийг садар самуунд уруу татах, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 18.5 дахин, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг 8.9 дахин өсжээ. Энэ бүх тоо статистикийг дурдаад өнгөрөх нэг хэрэг. Нугарч өссөн тоо хэмжээ, хувь бүрийн цаана Монгол хүний амьдрал, хувь заяа, амь нас, эрүүл мэнд, хүүхдийн ирээдүй насан туршид нь үл арилах сэтгэлийн шарх, гэмтэл үлдэж хоцорч байна.

Зөвхөн өнгөрсөн 2022 онд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас арван есөн тэрбум төгрөгийн хохирол учраад байна. Цахим гэмт хэргийн сэрдхийлгэм жишээнүүд бидний хажууд илхэн байна. Үүнээс заримаас нь дурдвал Иргэн Е иргэн С 2019 оноос цахим сүлжээ ашиглаж иргэдийн интернэт банкны дансанд нэвтэрч мөнгийг нь шилжүүлэн авдаг гэмт хэргийг байнга амьдралын эх үүсвэрээ болгосон байгаа бөгөөд 100 гаруй удаагийн үйлдлээр 1 тэрбум төгрөгийг иргэдээс залилж авсан байна. Сэжигтнийг Эрүүгийн цагдаагийн газрынхан 2021 оны 12 дугаар сард АНУ-аас баривчилж авчирсан байна.

Хоёрт, иргэн А фэйсбүүк хаягаар насанд хүрээгүй охидтой харилцан нүцгэн зураг солилцож, олон нийтийн сүлжээнд цацна гэж заналхийлэх замаар дахин нүцгэн зургийг нь авхуулах, ёс бус бичлэг хийлгүүлэх, удаан хугацаанд харилцсан охидтой уулзаж бэлгийн харьцаанд орсон хэргийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 13.5, 13.1 гурвын нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тус тус зааснаар 20 жилийн хорих ял иргэн А-д оногдуулсан.

Гуравт, 2022 оны 2 дугаар сард иргэн Э нь хүүхдүүд нэртэй нууц групп чат шинээр нээж насанд хүрээгүй хүүхдүүдийг садар самуун агуулсан дүрс бичлэгийг түгээж, иргэдэд төлбөртэйгөөр үзүүлсэн. Хэргийг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсгээр 2 жил хорих ял оногдуулсан.

Дөрөв, иргэн Г нь бага насны хүүхдүүд ихэвчлэн ашигладаг. Лайки аппликэйшнд эмэгтэй хүүхдийн профайл зурагтай хаяг үүсгэж насанд хүрээгүй

охидтой үеийн охины дүрээр харилцаа үүсгэж, эцэг эхээс далдуур нууц яриа өрнүүлэх, садар самуун агууламж бүхий харилцаа үүсгэж нүцгэн зургийг нь авдаг байсан бөгөөд үргэлжлүүлэн манай ахтай харилц, видео дуудлага хий. Тэр хүний хий гэснийг хий үгүй бол чиний зураг, бичлэгийг олон нийтийн сүлжээнд цацна. Эцэг эх сургуулийн хүрээллийн хүмүүст чинь үзүүлнэ гэх мэтээр дарамталж өөрийн ашигладаг фэйсбүүк хаягаар өөр хүний дүрд тоглож хохирогч хүүхдүүддээ видео дуудлага хийж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангадаг байсан хэрэгт шүүхээс 6 жил 8 сарын хорих ял оногдуулсан байна. Нийт 20 орчим хэргийн үйлдэлтэй.

Тав, Жон Ли гэх нэртэй фэйсбүүк хаягтаа гадаад улсын иргэн Монгол Улсын иргэн Д-тэй 2022 оны 8 сараас эхлэн фэйсбүүк чатаар харилцаж эхэлсэн бөгөөд өөрийгөө Англи улсын иргэн эхнэрээсээ салсан, 11 настай охинтой хамт амьдардаг. НҮБ-ийн энхийг сахиулах ажиллагаанд оролцдог, хөлсний цэрэг гэх мэтээр өөрийгөө google translate-ийг ашиглаж монгол хэлээр танилцуулан удаан хугацаанд харилцсан. Аав нь өмнө нь Монгол улсад амьдарч байсан, Монгол эмэгтэй хүнтэй гэрлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлэн иргэн Д-д бэлэг илгээсэн. Шуудангийн зардал хил, гаалийн хураамжийг түр шилжүүлж өгөхийг хүсэж. Монголд ирснийхээ дараа буцааж өгье хэмээн хууран мэхэлж, 4 удаагийн шилжүүлгээр нийт 22,529 америк долларыг Кумар Охаши гэх хүний данс руу шилжүүлэн авч залилсан хэрэг шүүхээр шийдвэрлэгджээ.

Айж сүрдсэн, дарамт шахалтад өртсөн, хаана хэнд хандахаа мэдэхгүй улмаас бүртгэлд ороогүй, гомдол гаргаагүй, хохирол нь тогтоогдоогүй гэмт хэрэг зөрчил хэдэн арваараа биш хэдэн мянгаараа нуугдан хоцорч үлдэж байна. Тэр хэрээр гэмт хэрэгтнүүд өөгшин амтшиж, илүү олон хүнийг хохироож байна гэсэн үг. Цахим орчинд дахь гэмт хэрэг огцом хурдан өсөж байхад түүнээс урьдчилан сэргийлэх шийдвэртэй тэмцэх ажил удаан байна. Хуучинсаг байна. Шинэ орчны гэмт хэрэгтэй шинэ орчинд нь тэмцэхгүй бол хурдан машинтай малын хулгайч нарыг мориор хөөхтэй зарчмын хувьд ялгаагүй.

Олон талын хүчин зүйл бий ч бүгдийг нь биш үндсэн гол 3 шалтгааныг нь онцлон хөндмөөр байна. Үүнд,

Нэгд, цахим орчинд Хүний эрхийг хамгаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль, хууль эрх зүйн орчингүй. Олон нийтийн сүлжээний талаар төрөөс баримтлах бодлого тодорхойгүй. Гэмт хэрэгтэй тэмцэх хүний нөөц, техник технологийн боломж муу. Уламжлалт бус орчинд гарч байгаа гэмт хэрэгтэй уламжлалт аргаар тэмцээд үр дүнгүй. Дэлгэцийн цаанаас өндөр хурдаар тархааж, өргөн олон хүнийг хамарч үндэстэн улсаар нь хохироодог нарийн заль мэх, арга технологи ашигласан гэмт хэрэгтэй өндөр хурдтай үр дүнтэй тэмцэх ийм нөхцөл байдал биднээс шаардаж байна. Технологи ашигласан гэмт хэрэгтэй технологи ашиглаж тэмцэхийг цаг үе та биднээс шаардаж байна.

Хоёр, хэрэглээнд өргөн хүрээнд нэвтэрсэн Фэйсбүүк гэх мэт олон нийтийн сүлжээ эрхлэгчидтэй харилцан ойлголцох, хамтран ажиллах нөхцөлөө тохирч чадаагүй зөрчилтэй контент гэж яг юуг хэлэх, хэрхэн тэмцэх талаар ойлголтын эрс зөрүүтэй байдал явж ирлээ. Монгол Улсаас янз бүрийн байгууллагууд иргэд хүний эрхэнд халдсан гэмт хэрэг өдөөсөн мэдээллийг устгуулахаар хандахад 18 хувь буюу 5 тохиолдлын зөвхөн 1-ийг нь шийдвэрлэсэн. Харин ийм хуультай

цахим орчинд хүний эрхийг хамгаалж чаддаг Герман улсад энэ үзүүлэлт 95 хувьтай байна. Хэн ямар байгууллага, үйлчилгээ эрхлэгчтэй харилцах, зөрчилтэй контентыг илрүүлж нотлон мэдээлэх нь тодорхойгүй. Анагаах ухаанаар бол олон хүнийг хохироох, халдвартай өвчинтэй тэмцэх, түргэн тусламж оношлох тусгаарлах арга хэмжээ эрс үгүйлэгдэж байна.

Гурав, иргэдийнхээ цахим мэдлэг боловсролд анхаараагүй, зохистой хэрэглэхийг нь төлөвшүүлээгүй, хуурамч мэдээлэл зохион байгуулалттай, тодорхой зорилготой нөлөөллөөс өөрийгөө хамгаалах дархлаа муу зэргээс болсон байна. Эцэг эхчүүдийн 95 хувь нь хүүхдээ цахим гэмт халдлагаас хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байна. Хүүхэд биеэрээ эцэг эх, багшийнхаа хараа хяналтад хажууд иргэд гэр орондоо байлаа ч оюун санаа, эрх чөлөөнд нь хэн ч хаанаас халдаж болдог, хил хязгаар хаалга үүдгүй шинэ орчинд бид амьдарч байна.

Иймд олон нийтийн сүлжээнд хүний эрх, хууль ёсны, ашиг сонирхлыг хамгаалах, ялгаварлан гадуурхалд өртдөггүй үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ баталгаатай эдэлдэг байх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Мөн түүнчлэн олон нийтийн сүлжээнд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчилтэй контентыг нэн яаралтай тодорхойлох, олж илрүүлэх, таслан зогсоох, цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх нь энэ хуулийн үндсэн зорилт.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулиар хүний захидал харилцааны нууцад халдахгүй. Олон нийтийн буюу 3 ба түүнээс дээш хэрэглэгчдээ цахим сүлжээнд нийтэд хүний эрхэнд халдсан гэмт хэргийн шинж бүхий сөрөг агуулгатай контент нийтлэх, түгээх харилцаанд хамааруулж зохицуулсан. Хэрэглэгчийн эрх үүрэг, хүний эрхийг зөрчсөн гэмт хэргийн агуулга бүхий контенттой тэмцэх тогтолцоог тогтоож өглөө. Олон нийтийн сүлжээний үйлчилгээ үзүүлж байгаа этгээд гэж хэнийг хэлэх, ямар эрх үүрэгтэй байх, зөрчилтэй контенттой холбогдуулан хэрэглэгчээс ирсэн гомдол мэдээллийг шийдвэрлэх, хэрэв Монгол Улсаас бүртгэлтэй 300 мянга ба түүнээс дээш тооны хэрэглэгчдээ бол Төлөөлөгчийн газраа нээж ажиллуулах, хэрэглэгчийг баталгаатай утасны дугаар, эсвэл цахим шуудангийн хаягаар баталгаажуулан бүртгэх, зөрчилтэй контентын талаарх олон нийттэй харилцах нэгжийн хүсэлт, шийдвэрийг хүлээн авч 7 хоногийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй болохыг тусгалаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах нь төр дангаар хийж хүчрэх ажил биш ээ. Тиймээс технологийн салбарын мэргэжлийн шинжээч судлаачид, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд Хүний эрхийн Үндэсний Комиссын идэвхтэй оролцох өргөн бололцоог хуульчлан баталгаажууллаа. Зөрчилтэй контентыг хянан шийдвэрлэх олон нийтийн сүлжээний эрхлэгчтэй хамтран ажиллах нэгж байна. Хүний эрхийг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй контентыг 24 цагаар тасралтгүй илрүүлж, оношлон тодорхойлж, нэн яаралтай горимоор сүлжээ эрхлэгчид нотлон



мэдээлэх үүрэгтэй ажиллана. Уг нэгжийг улсын төсөвт нэг ч төгрөгийн нэмэлт зардал гаргахгүйгээр Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн бүтцэд багтаан байгуулахаар хуулийн төслийг боловсрууллаа.

Засгийн газрын яамд, холбогдох байгууллагуудаас санал авч, төсөл боловсруулах ажилд оролцоог нь хангаж ажилласан болно. Түүнчлэн хувь хүний хуулиар тогтоосон алдар нэр хүндийг хүндэтгэх зарчмыг бэхжүүлэх үүднээс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд хүний хувийн мэдээллийг хуулийн дагуу олон нийтэд хүргэхдээ мэдээллийн эзэнд нь мэдэгдэл хүргэх зарчмыг баримталж нийтийн албан тушаалтан, төрийн байгууллага хувь хүний мэдээлэлд хүндэтгэлтэй хандах, ямарваа байдлаар олон нийтийн сүлжээнд дэлгэдэг зохисгүй байдлыг бүрмөсөн хориглох болно.

Үүний эхлэл болгож Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж байгаа бөгөөд удаа дараа татварын зөрчил гаргасан хүний хувьд тухайн хүнд нь мэдэгдэл хүргэсний үндсэн дээр зөвхөн нэр төр, татвар төлөгчийн дугаар, зөрчлийн мэдээллийг олон нийтэд мэдээлж, нийтэлж болох тухай агуулгуудыг тусгалаа.

Эрхэм гишүүд ээ, Уг хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

**Б.Энх-Амгалан:** Учрал сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Асуулт асуух гишүүн алга байна. Хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд саналаа өгнө үү. Санал хураалт. Санал хураалтын дүнг танилцуулъя. Наранбаатар гишүүн дэмжсэн санал өгсөн. Гэхдээ энэ дээр техник гацсан учраас эсрэг гарсан байна. Энийг протоколд тэмдэглэе. 11 гишүүн санал өгснөөс 10 гишүүн дэмжиж 90 хувийн саналаар уг хуулийн төсөл дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Наранбаатар гишүүн танилцуулъя.